



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.05.14 № 01/833

танай _____-ны № _____-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан ЭТТХК/20240101475 дугаартай “Цанхийн зүүн уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Дээрх тодруулга нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

Хавсралт 3 хуудастай.

ЗАСГИЙН ГАЗРЫН
ОНЦГОЙ БҮРЭН
ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ



Ж.ГАНБАТ

1124050469



Тодруулгын хариу

Тендерийн нэр	Цанхийн зүүн уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлын гүйцэтгэгчийг сонгох ажил
Тендерийн дугаар	ЭТТХК/20240101475
Тендер зарласан огноо	2024 оны 04 дүгээр сарын 19
Тендер нээх огноо	2024 оны 05 дугаар сарын 17
Тодруулга	Хариу
<p>Асуулт: Тендерт оролцогчоос дээрх ТББ-д заасан машин механизм, тоног төхөөрөмжийн танилцуулгыг ТББ-ын бүлэг 5-ын Маягт 3 эсхүл Ажлын даалгаврын 2.4-т заасан Хүснэгт №4 зэрэг материалын аль загварыг баримталж хүргүүлэх вэ?</p>	<p>Тендерийн баримт бичгийн тендерийн өгөдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг V бүлгийн Маягт 3 болон ажлын даалгаврын Хүснэгт №4-ийн дагуу тус тус бэлтгэн ирүүлнэ.</p>
<p>Асуулт: Үйлдвэрлэгчийн албан ёсны мэдээллийг үндэслэн компани Хавсралт 1-т оруулсан загварын дагуу бэлтгэсэн техникийн үзүүлэлт бүхий танилцуулгыг ТШЗ-ийн 19.2 /2.2/-т заасан шаардлагыг хангасан гэж үзэх үү?</p>	<p>Тендерийн баримт бичгийн тендерийн өгөдлийн хүснэгтийн ТШЗ 19.2-ын 2-д Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн нотлох дараах баримт бичиг ирүүлнэ.</p> <p>2.2. Машин механизмын үйлдвэрлэгчээс гаргасан техникийн үзүүлэлт бүхий танилцуулга ирүүлнэ. /Танилцуулгад үндэслэн ажлын даалгаварт шаардсан машин механизмын хүчин чадлыг тооцох ба үйлдвэрлэгчийн вэб сайт дээрх мэдээллийг үндэслэн хүчин чадлыг шаардлагад нийцэж буй эсэхийг нягтлана./</p> <p>гэж заасны дагуу үйлдвэрлэгчээс гаргасан албан ёсны танилцуулгыг өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.</p>
<p>Асуулт: Тоног төхөөрөмжийн төлбөрийг хуваарийн дагуу төлж дуусах үед өмчлөх эрхийг шилжүүлэх нөхцөл бүхий санхүүгийн түрээс (лизинг)-ийн гэрээний дагуу худалдан авч буй тохиолдолд уг тоног төхөөрөмжүүдийг ТШЗ-ийн 19.1.2-т заасан өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмжид оруулан тооцож ойлгох нь зөв үү?</p>	<p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, машин механизмын эзэмшигчийн талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ээр дамжуулан АТҮТ-ийн системд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн шалгах тул санхүүгийн түрээсийн гэрээтэй бол АТҮТ-ийн систем дээрх эзэмшигчийн мэдээллийг шалгаж, тендерт оролцогчийн нэрээр бүртгэгдсэн эсэхийг нягтлах шаардлагатайг анхаарна уу. /Энэхүү мэдээллийн санд тендерт оролцогчийн мэдээлэл үнэн зөв бүртгэгдсэн эсэх дээр Захиалагчийн зүгээс ямар нэгэн хариуцлага хүлээхгүй./</p>
<p>Асуулт: Түрээсийн гэрээний дагуу түрээслэх тоног төхөөрөмж нь Түрээслүүлэгч компанийн бүрэн эзэмшилд байгаа боловч тухайн тоног төхөөрөмжийг худалдан авахдаа банкны санхүүжилтээр худалдан авсантай холбоотой Түрээслүүлэгч нь Банкны өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд Автотээврийн Үндэсний мэдээллийн санд өмчлөгчөөр бүртгэгдээгүй бөгөөд санхүүжүүлэгч банк өмчлөгчөөр бүртгэгдсэн байна.</p> <p>Тодруулбал, тоног төхөөрөмжийг худалдагч нь өмчлөх эрхээ шилжүүлсэн боловч банк нь худалдан авагч буюу түрээслүүлэгчид олгосон зээлийн санхүүжилтийн эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилготой өөрийн өмчлөлд бүртгүүлсэн бөгөөд түрээслүүлэгчийг ийнхүү манай компанид тухайн тоног төхөөрөмжийг түрээслүүлэхийг зөвшөөрсөн болно. Мөн тендерийн</p>	<p>Түрээсийн ашиглах тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь банкны өмчлөлд байгаа тохиолдолд түрээсийн гэрээг холбогдох нотлох баримтыг ирүүлнэ.</p> <p>/Жишээ нь: банк түрээслүүлэгчийн хооронд байгуулсан гэрээ, банкны нэр дээр байгаа тоног төхөөрөмж, техник хэрэгслийг ашиглахад татгалзах зүйлгүй тухай банкны тодорхойлолт зэрэг/</p>

<p>баримт бичигт машин механизмыг түрээсээр ашиглахад түрээслүүлэгч нь заавал тухайн тоног төхөөрөмжийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээд байх тухай тусгагдаагүй байна. Энэ тохиолдолд уг тоног төхөөрөмжийг дээр дурдсан түрээсийн гэрээний шаардлагыг хангасан гэж үзэх үү?</p>	
<p>Асуулт: Тоног төхөөрөмж худалдан авахаар гадаадын хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан бөгөөд тухайн тоног төхөөрөмжүүд нь тендерийн материал илгээх үеийн байдлаар Монгол Улсын хилээр орж ирээгүй байх боловч ажил эхлэх үед бэлэн байх боломжтой тохиолдолд уг тоног төхөөрөмжүүдийг ТШЗ-ийн 19.1.2-т заасан Гүйцэтгэгчийн өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж гэсэн ойлголтод хамааруулж дээрх шалгуурыг хангасан гэж үзэх үү?</p>	<p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, машин механизмын эзэмшигчийн талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ээр дамжуулан АТҮТ-ийн системд бүртгэгдсэн мэдээллийг шалгах тул худалдах, худалдан авах зэрэг гэрээгээр шинэ техник тоног төхөөрөмж худалдан авсан, техник тоног төхөөрөмж тээвэрлэлтийн замдаа ирж байгаа тохиолдлыг үнэлгээнд харгалзан хянан үзэхгүй болохыг мэдэгдэж байна.</p>
<p>Асуулт: Тоног төхөөрөмж түрээслэхээр гадаадын хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан бөгөөд тухайн тоног төхөөрөмжүүд нь тендерийн материал илгээх үеийн байдлаар Монгол Улсын хилээр орж ирээгүй байх боловч ажил эхлэх үед бэлэн байх боломжтой тохиолдолд уг тоног төхөөрөмжүүдийг үндсэн тоног төхөөрөмж гэсэн ойлголтод хамааруулж дээрх шалгуурыг хангасан гэж үзэх үү?</p>	
<p>Асуулт: Туслан гүйцэтгэгчээр ажиллах этгээд нь Тоног төхөөрөмжийг худалдан авахаар гэрээ байгуулсан бөгөөд тус тоног төхөөрөмж нь тендерийн материал илгээх үеийн байдлаар Монгол Улсын хилээр орж ирээгүй байх боловч ажил эхлэх үед бэлэн байх боломжтой тохиолдолд уг тоног төхөөрөмжүүдийг ТШЗ-ийн 19.1.2-т заасан үндсэн тоног төхөөрөмжийн тоонд багтааж тооцож болох эсэх?</p>	
<p>Асуулт: Энэ нь Өгөгдлийн хүснэгтэд заасан ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шалгуурын 1-4 дэх мөрөнд заасан техникийн нийлбэр дүнгээс тооцогдох уу? эсхүл мөр тус бүр буюу техник тус бүрээс тооцон дээр дурдсан чадавхын шаардлагыг тооцох уу?</p>	<p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалтын мөр тус бүрийн шаардлагыг хангасан байна. /Жишээ нь: 20-38 м³-ын утгуурын багтаамжтай Экскаватор 9 ширхэгийг санал болгохоос 7-оос доошгүй нь өөрийн эзэмшлийнх байна./</p>
<p>Асуулт: ТШЗ 19.1 (2)-т заасны дагуу Тендерт оролцогчийн үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага буюу “Экскаваторуудын хувьд 7, 5, 6-аас доошгүй нь, харин Автосамосвалуудын хувьд 70 хувиас доошгүй нь өөрийн эзэмшил” байна гэсэнд ТШЗ 19.2.2 /2.6/-т “Түрээсээр ашиглах бол түрээсийн гэрээг ирүүлнэ...” гэж заасан нь хамаарах эсэх?</p>	<p>Өөрийн эзэмшлийнх байх гэж зааснаас бусад тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь түрээсийн гэрээтэй байж болно.</p>
<p>Асуулт: Тендерт оролцогчдоос жагсаалтын 8-12-т заасан эдгээр ажилтнуудын талаарх баримт бичгийг мэдээллийн системд оруулсан байх шаардлагатай юу?</p>	<p>Тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-ын 1-д тусгагдсан ажил гүйцэтгэх хүний нөөцийг цахим системээр дамжуулан санал болгоно. Инженер техникийн ажилтнууд нь тухайн аж ахуйн нэгжид ажилладаг үндсэн ажилтан байна.</p>
<p>Асуулт: ТШЗ-ийн 19.2 (1)-т заасан тендерт оролцогчийн үндсэн ажилтан, хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажиллах ажилтан гэдэгт зөвхөн ТШЗ-ийн 19.1 /1/-т заасан хүснэгтэд заасан ажилтнуудыг гэж ойлгох уу эсхүл эдгээр ажилтнуудыг оролцуулаад Тендерт оролцогч компанийн бусад үндсэн ажилтнуудын мэдээллийг мөн оруулна гэж ойлгох уу?</p>	
<p>Асуулт: Тендерт оролцогч нь дээр заасан баталгааны албан бичгийг хүргүүлэхэд нотлох баримтаар дурдсан даатгалын гэрээнүүдийг хүргүүлэх шаардлагатай эсэх?</p>	<p>Ажлын даалгаврын 2.3.-д заасны дагуу шалгарсан тохиолдолд ажил эхлэх болон гүйцэтгэх үед холбогдох даатгалд хамрагдсан байна.</p>
<p>Асуулт: Туслан гүйцэтгэгч компани оруулах тохиолдолд энэхүү тендерт зориулан тусгайлан гэрээ байгуулах шаардлагатай эсэх, эсхүл өмнө байгуулсан хэрэгжүүлж буй гэрээний дагуу ажиллуулах боломжтой юу? Мөн гэрээний хугацаа төслийн хэрэгжих хугацаагаар буюу</p>	<p>Тендер шалгаруулалтад түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй оролцох бол тухайн төсөл арга хэмжээнд зориулан байгуулсан гэрээг цахим системээр баталгаажуулан ирүүлнэ.</p>

<p>ажил эхэлснээс 36 сарын хугацаатай байхыг заавал шаардах уу?</p>	<p>Туслан гүйцэтгэгч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-дэх хэсэгт заасны дагуу санал ирүүлж болох ба тендерийн баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Гэрээний хэрэгжих хугацаа 36 сар байна.</p>
<p>Асуулт: Туслан гүйцэтгэгчийн үндсэн эзэмшлийн техникийг Гүйцэтгэгчийн эзэмшлийн техникт оруулан, ТШЗ-ын 19.1 (2)-т заасан тендерт оролцогчийн захиалагчид санал болгох үндсэн техникүүдийн тодорхой хувь нь өөрийн эзэмшлийн байх тухай шаардлагад оруулж үнэлэх үү?</p>	<p>Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 17.3-д “Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.” 17.4-д “Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-өөс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.” гэж заасны дагуу төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д заасан шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийн шаардлагыг хамтдаа бүрэн хангасан байна.”</p>
<p>Асуулт: ТШЗ-ийн 17.4-т заасан шаардлагын хувийг ТШЗ-ийн 19.1.2-т заасан эзэмшигчийн мэдээлэл гэсэн үндсэн тоног төхөөрөмжийн хамгийн багадаа байх хувиас тооцож бодох эсэх?</p>	<p>Түншлэлээр оролцож буй тохиолдолд оролцогч хуулийн этгээд тус бүр ажиллах хүчний мэдээллийг бөглөж цахим системээр хүргүүлэх үү эсвэл аль нэг оролцогч нь хангахад ажиллах хүчний шаардлагыг хангаснаар тооцох уу?</p> <p>Асуулт: Тендерт түншлэлээр оролцож буй хуулийн этгээдүүдийн хувьд тендерийн бичиг баримтыг дээрх шаардлагад хэрхэн нийцүүлж хүргүүлэх талаар дэлгэрэнгүй тодорхойлж өгнө үү? Мөн, ТШЗ-ын 15.1 (3)-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг Түншлэлийг төлөөлөн эрхтэй этгээд нь тендер илгээх холбогдох хэсэгт сонгож илгээнэ” гэж заасантай адил бусад албан бичиг, баталгааг мөн адил зарчмаар илгээх эсэх</p> <p>Асуулт: Тендерт оролцогч тендерийн баримт бичгийг Pdf болгон нэгтгэж tender.gov.mn сайтаар дамжуулан хүргүүлэхэд нийт баримт бичгийн хэмжээнд тавигдах дээд хязгаарын шаардлага бий юу?</p> <p>Асуулт: Захиалагчаас шаардсан ТББ 19.2 (4.1-4.9)-д заасан албан бичиг, баталгаа, мэдэгдэл, болон ТББ-т заасан бусад тодорхойлолт лавлагаа зэрэг баримт бичгийг түншлэлээр оролцож буй хуулийн этгээдүүдийн хувьд төлөөлөх эрхтэй этгээдээр дамжуулж нэгдсэн байдлаар хүргүүлэх эсэх, эсхүл түншлэлийн гишүүн нь тусдаа хуулийн этгээд болохын хувьд тус бүр гаргаж хүргүүлэх эсэхийг тодруулж өгнө үү.</p> <p>Худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ийн хэрэглэгчийн хөтөч хэсгээс тендер илгээх зааварчилгаатай танилцна уу.</p> <p>Түншлэлээр оролцох бол хуулийн 6 дугаар зүйл, тендерийн баримт бичгийн ТШЗ 16, ТШЗ 17-д заасны дагуу тендер ирүүлнэ.</p>

Жич: Энэ бүх тодруулгыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн тендер ирүүлэхийн өмнөх уулзалтаар тендер оролцохыг сонирхогч этгээдүүдэд дэлгэрэнгүй тайлбарласан болно.